



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/118

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боржигон Тавнангууд овогт Данзандаржаа Гансүх нь (ЕЙ64022306) Сүмбэр сумын Найрамдал багийн Найрамдал хотхон 15-р байрны ар талд байрлах гараашийн зориулалттай 20м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Эншүбэ овогт Насанбатын Батдэлгэрт (ЕД88050674) Сүмбэр сумын Найрамдал багийн Найрамдал хотхон 45-Г/10 тоотод байрлах 20м² газрыг гараашийн зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (Н.Батдэлгэр)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Н.Батдэлгэрт эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны А/119 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Г.БАТСУУРЬ

4212400277



Аймгийн Засаг даргын 2024 оны
03. сарын 26.-ны өдрийн 11/118 дугаар
захирамжийн хавсралт



Еншүбэ овогт Насанбатын Батдэлгэрийн эзэмшилд
шилжүүлж байгаа газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	3	20	15	Гарааш	Найрамдал хотхон 45-Г/10 тоот

